



**ХЭНТИЙ АЙМГИЙН
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 06 сарын 18 өдөр

Дугаар

1/14

Хэрлэн сум

**Албан тушаалын тодорхойлолт
батлах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам батлах тухай” 03 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Төрийн албаны зөвлөлийн 2024 оны “Зөвшөөрөл олгох тухай” 213 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын Захиргаа хяналтын хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 1 дүгээр хавсралтаар, хяналт, шалгалтын улсын байцаагчийн албан тушаалын тодорхойлолтыг 2 дугаар хавсралтаар, нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагчийн албан тушаалын тодорхойлолтыг 3 дугаар хавсралтаар, хүний нөөц хуулийн мэргэжилтэний албан тушаалын тодорхойлолтыг 4 дүгээр хавсралтаар, бичиг хэрэг, дотоод асуудал, хөрөнгө хариуцсан мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтыг 5 дугаар хавсралтаар, мэдээллийн технологийн мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтыг 6 дугаар хавсралтаар, сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтыг 7 дугаар хавсралтаар, Санхүү бүртгэл, хамралт, орлогын хэлтсийн даргын ажлын байрны тодорхойлолтыг 8 дугаар хавсралтаар, сангийн бүртгэл хариуцсан мэргэжилтэний ажлын байрны тодорхойлолтыг 9 дүгээр хавсралтаар, хамралт, орлого, шимтгэлийн өр хариуцсан байцаагч, мэргэжилтэний ажлын байрны тодорхойлолтыг 10 дугаар хавсралтаар, сайн дурын даатгалын байцаагч, мэргэжилтэний ажлын байрны тодорхойлолтыг 11 дүгээр хавсралтаар, Тэтгэвэр тэтгэмжийн хэлтсийн даргын ажлын байрны тодорхойлолтыг 12 дугаар хавсралтаар, тэтгэвэр, тэтгэмжийн хяналтын байцаагч, мэргэжилтэний ажлын байрны тодорхойлолтыг 13 дугаар хавсралтаар, магадлагч эмчийн ажлын байрны тодорхойлолтыг 14 дүгээр хавсралтаар, тэтгэврийн тогтоолт, олголтын байцаагч, мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтыг 15 дугаар хавсралтаар, тэтгэмжийн тогтоолт, олголтын байцаагч, мэргэжилтэний ажлын байрны тодорхойлолтыг 16 дугаар хавсралтаар, Бор-Өндөр сумын Нийгмийн даатгалын тасгийн даргын ажлын байрны тодорхойлолтыг 17 дугаар, нэг цэгийн үйлчилгээний байцаагч, мэргэжилтэний ажлын байрны тодорхойлолтыг 18 дугаар хавсралтаар, сумын байцаагч, мэргэжилтэний ажлын байрны тодорхойлолтыг 19 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэ тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хяналтын хэлтсийн дарга /Н.Цолмонбаяр/-д даалгасугай.

ДАРГА



Н.НЯМХАТАН

240401050